




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ  
**4892 СЯА АМ.ДОЛЛАР**



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ  
**11.3%**



НИЙТ ХАДГАЛАМЖ  
**19.2 ИХ НАЯД ТӨГ**



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР  
**32.1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР**



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ  
**1084 ТЭРБУМ ТӨГ**



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ  
**6%**

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: **5.1%**,  
Инфляци: 2021 онд: **8.2%**,  
Урсгал тэнцэл: 2021 онд: **-8.3%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: **6%**  
Инфляци: 2021 онд: **5.5%**,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: **-13.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORg>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 4-р сарын байдлаар (490.5) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 23.4 хувиар өссөн бол, зарлага 48.6 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 490.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 23.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



**Ам.долларын ханш өмнөх сараас 0.26 төгрөгөөр өссөн байна.**

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 66.7 төгрөг буюу 2.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.26 төгрөгөөр өсч 2849.90 төгрөг болов. 4-р сард гадаад валютын нөөц 4.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар өсч, оны эхнээс 7.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




**Инфляцийн түвшин 5.6%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 4-р сарын байдлаар өмнөх сараас 2.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, оны эхнээс 5.5 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.




**Гадаад худалдааны тэнцэл 535.4 сая.ам долларын ашигтай гарав.**

2021 оны дөрөвдүгээр сард нийт барааны эргэлт 4457.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 50 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 81.7 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 535.4 сая ам.долларын ашигтай гарав.



## 4-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ДНБ 2021 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 22.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 42,459 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 15.7 хувиар өсөв. Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2021 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 9.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (22.5%) их наяд төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 496.7 (15.7%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө. ДНБ-ий 2021 оны эхний улиралд эцсийн хэрэглээнд 67.1 хувь, хөрөнгийн нийт хуримтлалд 29.7 хувь, цэвэр экспортод 3.2 хувь нь зарцуулагдаж, өмнөх оны мөн үеэс эцсийн хэрэглээ 21.1 пунктээр, хөрөнгийн нийт хуримтлал 3.5 пунктээр буурчээ.

## САРЫН ОНЦЛОХ

**ГУРВАН ХУВИЙН ЗЭЭЛД 321 ТЭРБУМ ТӨГРӨГ ОЛГООД БАЙНА**

- Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд 4033 иргэнд 152,3 тэрбум төгрөг, 712 ААН-д 168,7 тэрбум төгрөгийн ажлын байр дэмжих зээл олгожээ. Олгосон зээлийн 1661 нь нийслэлд, 3084 нь аймаг, орон нутгийн зээлдэгч нар байна. Нийт дүнгээр 4 745 зээлдэгчид 321 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгоод байна. Ажлын байр дэмжих зээлийг олгосноор, одоогийн байдлаар 29 321 ажлын байрыг хадгалж үлджээ. Монголбанкны репо санхүүжилт буюу дахин санхүүжилтийн зээлийн хувьд 1 437 зээлдэгчид 210,4 тэрбум төгрөгийг олгосон бол ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг 2 488 зээлдэгчид 186,7 тэрбум төгрөгийг олгожээ.

**ЭРДЭС БАЯЛГИЙН ЭКСПОРТ 18-21 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА**

- Манай улс энэ онд 37.2 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөснөөс оны эхний 3 сарын байдлаар 6.7 сая тонныг гаргаж 18 хувийн гүйцэтгэлтэй байна. 4 дүгээр сарын байдлаар 6.8 сая тонн нүүрс экспортолсныг оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспорт 3.5 сая тонноор өссөн үзүүлэлттэй байна. Мөн 1.43 сая тонн зэс экспортлохоос 0.3 сая тонныг гаргаж 21 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд 8.9 сая тонн төмрийн хүдэр экспортлохоос оны эхний 3 сарын байдлаар 1.9 сая тонныг гаргаж 21 хувийн гүйцэтгэлтэй байна. 4-р сарын эцэст Лондоны металлын биржид нэг тонн зэсийн үнэ 1.6 хувиар өсөж, 9551.5 ам.доллар болов. Долларын ханш суларч, Чили улсын нийлүүлэлттэй холбоотой болгоомжлолын улмаас зэсийн үнэ өнгөрсөн долоо хоногт өсөж, 2011 оноос хойших хамгийн дээд амжилт үзүүлэв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2021 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)